

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 06 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

**Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох
тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Засгийн газрын 2013 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.6, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 2013 оны 06 сарын 06-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:


1. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ/нэг сарын/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээтэй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сарын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1,78 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын сарын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1,42 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээтэй байхаар тус тус шинэчлэн тогтоосугай;

2. Тогтоолын хэрэгжилтийг 2013 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн хангаж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч Г.Ганбатад үүрэг болгосугай;

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2012 оны 12 сарын 26-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

Б.БАТЗАЯА





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 265839,
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2013.05.20 № 18/1348
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
КОМПАНИУДЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ


Засгийн газрын хуралдааны
тэмдэглэл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлстэй холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд үүнтэй холбогдуулан Төрийн өмчийн хороо /Д.Цогтбаатар/-нд хэд, хэдэн заалтаар даалгавар өгсөн.

Дээрх тэмдэглэлийн 2.1.1 дэх хэсэг буюу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинтай холбоотой заалтыг шинээр тогтоон мөрдүүлж, дүнг 2013 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлэхийг үүрэг болгож байна.

Жич: Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ХЭГ/605 тоот албан бичиг, Засгийн газрын хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг хавсаргав.

ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



ОДМАА



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2013 он 4 дугаар
сарын 22 ны өдөр

Дугаар ХЭГ/605

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЦОГТБААТАР ТАНАА

Төрийн өмчийн төлөөлөгчдийн тухай


Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны албан хаагчийн цалин хөлстэй холбоотой асуудлыг хэлэлцсэн.

Уг хуралдаанаар төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулж байгаа дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн захиргааны албан хаагчийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 2 хүртэлх хуулийн этгээдэд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилдог байх, мөн тэдгээрийн нэг сарын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (нэг сарын)-г хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоох чиглэлийг өгсөн.

Иймд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинтай холбоотой асуудлаар гаргасан хуулийн этгээдийн шийдвэрийг Засгийн газраас өгсөн чиглэлд нийцүүлэхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсон Төрийн өмчийн хорооны шийдвэрийг эргэн харж, хяналт тавьж ажиллана уу.

Засгийн газраас өгсөн үүргийн дагуу холбогдох дүрэм, журмыг шуурхай боловсруулан баталж, дүнг холбогдох судалгаа, мэдээллийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ үү.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.



Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“XXII.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлстэй холбоотой асуудлыг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:


2.1. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулж байгаа дүрэм, журмыг Компанийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлах, ийнхүү батлахдаа дараахь асуудлыг тусгахыг Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд чиглэл болгов:

2.1.1. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн захиргааны албан хаагчийн нэг сарын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (нэг сарын)-г хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоох;

2.1.2. төрийн захиргааны албан хаагчийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 2 хүртэлх хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчөөр томилон ажиллуулж байхаар тоог нь хязгаарлах;

2.1.3. төрийн захиргааны албан хаагчийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилохдоо Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах.

2.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дээрх асуудлаар гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР